



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/1294

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид  
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 131 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Энэ захирамжийн хавсралтад заасан нийт 40,561,429.00 (дөчин сая таван зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун хорин ес) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 27,716,977.00 (хорин долоон сая долоон зуун арван зургаан мянга есөн зуун далан долоо) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 12,844,452.00 (арван хоёр сая найман зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөгийн үлдэх өртөг бүхий халаалтын зуухыг нийслэлийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан нийт 40,561,429.00 (дөчин сая таван зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун хорин ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий халаалтын зуухыг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээсээ хасахыг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ (Г.Баттулга)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205582

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
...11... дугаар сарын 09-ны өдрийн  
Р/1294 захирамжийн  
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Халаалтын зуух	МУХТ-0,7 мв	2020	40,561,429.00	27,716,977.00	12,844,452.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ	"Монголын төмөр зам" ТӨХК